

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2019 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

1.Аудитын гэрчилгээ	2
2.Аудитын тайлан.....	4
2.1. Оршил	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	4
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	5
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	6
2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	7
2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	8
2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	8
2.13. Шилэн дансны мэдээлэл.....	8
2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	8
2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	8
3.Менежментийн захидал.....	10
4.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	12
4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	12
4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	13
4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	15
4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	17
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	18
4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	20
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	21

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

УЛСЫН ГУРАВДУГААР
ТӨВ ЭМНЭЛГИЙН ЗАХИРАЛ
Ц.ТӨМӨР-ОЧИР ТАНАА

2020.02.27 № 06/639
танай _____ -ны № _____ -т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Улсын гуравдугаар төв эмнэлгийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Улсын гуравдугаар төв эмнэлгийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Улсын гуравдугаар төв эмнэлгийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.Аудитын тайлан

2.1. Оршил

Улсын гуравдугаар төв эмнэлгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Захирал Ц.Төмөр-Очир Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагналын системийг боловсронгуй болгох төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх данснаас хасах, шилжүүлэхтэй холбоотой зөвлөмжийг менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Улсын гуравдугаар төв эмнэлгийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Улсын гуравдугаар төв эмнэлгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 1 дүгээр сарын 30-наас 2020 оны 2 дугаар сарын 17-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 2 дугаар сарын 21-ний өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын захиалгаар “Баян ташаагийн эх Аудит” ХХК хариуцаж хэрэгжүүлэв.

Улсын гуравдугаар төв эмнэлэг 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2020 оны 1 дүгээр сарын 23-ны өдрийн 1/87 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Улсын гуравдугаар төв эмнэлгийн үйл ажиллагааны эрхэм зорилго: Бид өдөр тутмын эмнэлзүй, сургалт, судалгааны нэгдмэл үйл ажиллагааны тусламжтайгаар эрдэнэт хүний амь нас, эрүүл мэндэд үнэ цэнтэй өөрчлөлтийг бий болгохыг зорино.

Улсын гуравдугаар төв эмнэлгийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Улсын хэмжээнд эмнэлгийн төрөлжсөн мэргэжлийн тусламж үйлчилгээ үзүүлэх, анагаах ухааны сургалт, судалгаа явуулах, эрдэм шинжилгээний ажил эрхлэх, эмнэлгийн болон бусад байгууллага, иргэдэд мэргэжил арга зүйн гурав дахь шатны лавлагаа тусламжаар хангах

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх данснаас хасах, шилжүүлэх, журам батлах тухай ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоол
- Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай 2019 оны 268 дугаар тогтоол
- Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 24 дүгээр тогтоол Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээ
- Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 25 дугаар тогтоол Төрийн үйлчилгээний зарим албан тушаалын зэрэглэлийг шинэчлэн тогтоох тухай
- Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 276 дугаар тогтоол Төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэлийг шинэчлэн тогтоох
- Эрүүл мэндийн сайдын 2018 оны А/548 тоот тушаалаар баталсан Эрүүл мэндийн салбарын төрийн албан хаагчдын хоол, унааны хөнгөлөлт нэмэгдэл, урамшлын хэмжээг тогтоох тухай

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Улсын гуравдугаар төв эмнэлэг нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа “Ординат” ХХК-ийн Unicus 1.1 программ хангамж ашиглаж байна.

Улсын гуравдугаар төв эмнэлгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “бага” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Улсын гуравдугаар төв эмнэлгийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 14 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг дунд гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 43,847,372.5 мянган төгрөгөөс тооцон 438,473.7 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшин өөрчлөгдөөгүй байна.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Улсын гуравдугаар төв эмнэлгийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,541,496.6 мянган төгрөгөөр буюу 3.6 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт /мянган төгрөг/
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	17,153.9	-	(17,153.9)
Авлага	422,909.9	-	(422,909.9)
Урьдчилгаа			-
Бараа материал	3,203,130.3	2,827,611.0	(375,519.3)
Үндсэн хөрөнгө	39,255,419.2	38,529,505.7	(725,913.5)
Нийт хөрөнгө	42,898,613.3	41,357,116.7	(1,541,496.6)
Өр төлбөр		11,792.1	11,792.1
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	42,898,613.3	41,345,324.6	(1,553,288.7)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	42,898,613.3	41,357,116.7	(1,541,496.6)

Өмнөх онд 422,909.9 мянган төгрөгийн авлагын эхний үлдэгдэлтэй байсан нь байгууллагаас авах авлага 192,900.0 мянган төгрөг, нийгмийн даатгалаас авах авлага 3,978.2 мянган төгрөг, татаас санхүүжилтийн авлага 226,031.7 мянган төгрөг байна.

Бараа материалын үлдэгдэл 375,519.3 мянган төгрөгөөр буурсан. Үүнээс эм боох материал дансны үлдэгдэл хамгийн их буурсан байгаа нь Ангиографикын оношилгоо, эмчилгээний орчин үеийн шинэ аппарат суурилуулснаар хэвтэн эмчлүүлэгчдийн тоо өмнөх оноос нэмэгдсэнээр эм эмнэлгийн хэрэгслийн зарцуулалт өссөнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл буурсан нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн 444 тоот, 2019 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн А-1/3562 дугаар шийдвэрийг үндэслэж тоног төхөөрөмжийн данснаас 1,064,871.7 мянган төгрөг, тавилга хэрэгслийн данснаас 61,613.7 мянган төгрөг, нийт 1,125,802.6 мянган төгрөгийн хөрөнгийг акталсантай холбоотой байна.

Тайлант онд 216,463.3 мянган төгрөгөөр барилга байгууламжид их засвар хийсэн, 283,804.4 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 15,259.1 мянган төгрөгийн тавилга хэрэгсэл, 7,920.0 мянган төгрөгийн программ хангамж, 15,000.0 мянган бусад биет бус хөрөнгө худалдаж авсан, бусад эх үүсвэрээс 152,782.2 мянган төгрөгийн хөрөнгө барилга

байгууламж, 24,968.0 мянган төгрөгийн түргэн тусламжийн авто машин, 3,544,810.9 мянган төгрөгийн хөрөнгө тоног төхөөрөм, 110,484.6 мянган төгрөгийн тавилга хэрэгсэл үнэ төлбөргүй хүлээн авсан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл өсөж тайлант оны эцэст Цус сэлбэлт судлалын үндэсний төвд 11,792.1 мянган төгрөгийн өртэй нь яаралтай мэс заслын тоо нэмэгдсэнтэй холбоотойгоор цусны хэрэгцээ шаардлага гарч өр үүссэн.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдааны залруулга 198,185.6 мянган төгрөгийн бичилт нь дахин үнэлсэн хөрөнгө акталсантай холбоотой байна

2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Улсын гуравдугаар төв эмнэлэг нь 2019 онд 3,256,766.9 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 3,790,608.4 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 116 хувиар биелүүлсэн байна. Орлогын төлөвлөгөө 16 хувиар давж биелсэн нь өндөр өртөгтэй мэс заслын тусламж үйлчилгээний тоо өмнөх оноос 30 хувиар нэмэгдсэнтэй холбоотой. Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газартай 2019 оны 11 дүгээр сард санхүүжүүлэх нэмэлт гэрээ байгуулсан.

Тайлант онд төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрт зориулан 36,016,332.7 мянган төгрөгийн төсөв батлагдсан, үүнээс 35,841,562.4 мянган төгрөгийг урсгал зардалд, 174,770.3 мянган төгрөгийг бусад урсгал зардалд зарцуулахаар хуваарилсан байна.

Нийт зардлын 7,804,971.1 мянган төгрөгийг улсын төсвөөс, 24,954,594.7 мянган төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас, 3,076,049.9 мянган төгрөгийг үндсэн болох туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Улсын гуравдугаар төв эмнэлэг нь 2019 онд 36,016,332.7 мянган төгрөгийн урсгал төсвийг зарцуулахаар батлагдсанаас 36,002,836.7 мянган төгрөгийн зардал гаргаж төсвийг 13,496.0 мянган төгрөгөөр буюу 0.3 хувиар хэмнэж ажилласан байна.

Тус эмнэлэг нь тайлант оны эцэст 152,265.3 мянган төгрөгийн үр дүнгийн урамшуулал, 254,350.0 мянган төгрөгийн нэг удаагийн урамшуулал, нийт 406,615.3 мянган төгрөгийн цалингийн урамшуулал олгосон нь Сангийн сайдын 2019 оны 3 дугаар сарын 27-ны өдрийн 74 дүгээр тушаалтай нийцэж байна.

Тайлант онд батлагдсан орон тооноос 15 эмч, мэргэжилтэн илүү ажиллаж 84,479.1 мянган төгрөгийн цалинг олгосон байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Нэмэлт төсөв: Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан 6,566.5 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 2,402,816.0 мянган төгрөг, дээд шатны төсвийн захирагчаас хуваарилсан 146,222.4 мянган төгрөг, нийт 2,555,604.9 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж ажилласан байна.

Үүнээс Эмнэлгийн даргын 2019 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн Б/601 тоот тушаалыг үндэслэн ажилчдад олгосон цалин хөлс болон нэмэгдэл 184,352.5 мянган, хангамж бараа материалын зардалд 37,998.4 мянган, норматив зардалд 273,495.2 мянган, эд хогшил худалдан авахад 74,906.5 мянган, бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр, хураамжийн зардалд 192,080.5 мянган, бараа үйлчилгээний бусад зардалд 1,779,402.6 мянган, нийт 2,555,604.8 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 0.07 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 14 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 15 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 329,852.7 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 58,582.1 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 271,270.6 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өглөө. Үүнд:

1. Өндөр өртөгтэй тусламж үйлчилгээний төлбөрийн хувь хүн төлөх 25 хувийн төлбөрөөс 58,582.1 мянган төгрөг дутуу тушаасан нь Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөлийн 2018 оны 09 дүгээр сарын 11-ний өдрийн 17 дугаар тогтоолын 3.3-д “Даатгуулагчаас эрүүл мэндийн байгууллагад төлөх эмнэлгийн хэрэгсэл хиймэл цорго, портез, ортопедийн хэрэгслийн төлбөрийн хэмжээ нь тухайн эрүүл мэндийн байгууллагын ханган нийлүүлэгч байгууллагатай байгуулсан худалдан авах гэрээнд заасан хэрэгслийн үнийн дүнгээс Эрүүл мэндийн даатгалын сангаас төлсөн төлбөрийн дүнг хассан зөрүүгээр тооцно” гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн “эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэх.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Тус эмнэлэг нь 2019 онд эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авах тендерийн 54 багцад тендерийн техникийн тодорхойлолт гаргахдаа нь “Urised аппаратад тохирох” гэж тусгасан нь Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.3-д “барааны тэмдэг, нэр, хэлбэр маяг, төрөл, гарал үүсэл, үйлдвэрлэлийн арга, үйлдвэрлэгч буюу нийлүүлэгчийг тухайлан заасан шаардлага, нөхцөл тавихгүй”, 11.1.4-д “энэ хуулийн 11.1.3-т шаардлага, нөхцөлийг заах шаардлагатай бол түүний ард “эсхүл түүнтэй дүйцэх” гэсэн тодотгол хэрэглэх.” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна. Ингэснээр тендерт оролцох сонирхолтой этгээдүүдийн өрсөлдөөнийг хязгаарлахад хүргэсэн байж болзошгүй юм.

Уг “Urised” аппаратыг “Сетунари” ХХК 2018 оны 5 сараас эхлэн түр хугацаагаар ашиглуулах гэрээ байгуулан эзэмшүүлж байгаа нь энэ компанид давуу эрх олгосон гэх үндэслэлтэй байна.

Дараагийн аудитаар худалдан авах үйл ажиллагааг авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Улсын гуравдугаар төв эмнэлэг нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 148 удаагийн мэдээллийг хуулийн хугацаанд нь, 1 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 906,682.2 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага өгснийг хэрэгжүүлсэн байна.

Нийт 1 зөвлөмж өгснөөс хэрэгжилт 95 хувьтай байна.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Улсын гуравдугаар төв эмнэлгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Залруулагдаагүй 329,852.7 мянган төгрөгийн алдаа зөрчил нь бидний тогтоосон 438,473.7 мянган төгрөгийн материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул Зөрчилгүй дүгнэлт өгч байна.

“Зөрчилгүй” дүгнэлт

Улсын гуравдугаар төв эмнэлгийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.3 дугаар заалтын дагуу үнэн зөв илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Балансын данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Тайлант онд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын зөвшөөрөлгүйгээр 250,876.3 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэсэн.

Энэ нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх данснаас хасах, шилжүүлэх, журмын 4.2-д “Төсөвт хуулийн этгээд нь Төсвийн тухай хуулийн батлагдсан урсгал төсөв, нэмэлт төсөв, хэмнэсэн төсөв болон давсан орлогоос үндсэн хөрөнгө бэлтгэх бол хэрэгцээ, шаардлагаа тодорхойлж, зайлшгүй хэрэгцээтэй хөрөнгийн жагсаалт, тоо хэмжээ, худалдан авах үнийн дээд хязгаарын саналыг дээд шатны төсвийн ерөнхийлөн захирагч дэмжсэн тохиолдолд Төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага зөвшөөрөл олгоно” гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн “эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2. Эрсдэл:

Хууль тогтоомжийн хэрэгжилт хангагдахгүй байх, төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах.

1.3. Өгсөн зөвлөмж:

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх данснаас хасах, шилжүүлэх, журмыг мөрдөж ажиллах.

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

2. Нэмэлт санхүүжилтийн данстай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

МОН/006 төслийн санхүүжилтээс Баянхонгор аймгийн нэгдсэн эмнэлгийн зүрхний эхоны засварын санхүүжилт 18,000.0 мянган төгрөгийг 2019 оны 12 дугаар сарын 25-нд шилжүүлж гэрээний заасан хугацаанд засвар хийгдээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2 “төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх”, 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэж заасантай тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн “эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2.2. Эрсдэл:

Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх, өр авлага үүсэх.

2.3. Өгсөн зөвлөмж:

Люксембургийн хөгжлийн агентлаг болон Улсын гуравдугаар төв эмнэлгийн хооронд байгуулсан 2017 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн 17/1630 тоот гэрээнд заасан санхүүжилт болон хэрэгжилтийн заалтуудыг мөрдөж ажиллах.

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

3. Дотоод хяналттай холбоотой асуудал

3.1. Илрүүлэлт:

Албан тушаалын ангилал болон цалингийн шатлалыг буруу тогтоосноос 2,394.3 мянган төгрөгийн цалинг илүү олгосон.

Энэ нь Засгийн газрын 2019 оны 24 дүгээр тушаалын 7 дугаар хавсралтаар баталсан Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан тушаалын цалингийн сүлжээнд заасан цалингийн шатлалтай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн “эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.2. Эрсдэл:

Цалин хөлс илүү олгогдох.

3.3. Өгсөн зөвлөмж:

Засгийн газрын 2019 оны 24 дүгээр тушаалыг мөрдөж ажиллах

3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4.Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	3,643,194,144.48	2,827,611,021.35
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	17,153,897.85	-
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	16,710.00	-
31110	Төгрөг	16,710.00	-
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	17,137,187.85	-
3121	Төгрөг	696,100.75	-
31214	Бусад төсөл, нөөцийн харилцах	696,100.75	-
3122	Гадаад валют	16,441,087.10	-
31224	Бусад төсөл, нөөцийн харилцах	16,441,087.10	-
33	АВЛАГА	422,909,928.16	-
33300	Татаас, санхүүжилтийн авлага	226,031,686.00	-
335	Бусад авлага	196,878,242.16	-
3351	Байгууллагаас авах авлага	196,878,242.16	-
35	БАРАА МАТЕРИАЛ	3,203,130,318.47	2,827,611,021.35
351	Түүхий эд материал	1,021,513,290.57	361,695,462.43
35130	Эм боох материал	1,021,513,290.57	361,695,462.43
354	Хангамжийн материал	2,181,617,027.90	2,465,915,558.92
35410	Бичиг хэргийн материал	708,100.00	965,900.00
35420	Аж ахуйн материал	8,628,145.00	202,500.00
35440	Түлш, шатах тослох материал	4,343,908.65	3,884,807.04
35450	Барилгын засварын материал	-	320,000.00
35460	Хүнсний материал	3,271,600.40	2,445,853.00
35470	Бусад хангамжийн материал	2,164,665,273.85	2,458,096,498.88
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	39,255,419,227.58	38,529,505,740.89
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	39,255,419,227.58	38,529,505,740.89
392	Биет хөрөнгө	37,424,161,707.37	36,680,955,304.16
39201	Барилга, байгууламж, орон сууц	25,346,869,313.76	25,709,409,886.01
39202	Хуримтлагдсан элэгдэл	(23,575,833.07)	(988,082,352.37)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	239,295,750.00	263,688,791.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(208,849,977.72)	(221,881,206.21)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	29,670,231,834.66	32,458,420,425.05
39206	Хуримтлагдсан элэгдэл	(18,083,837,833.39)	(20,863,218,140.89)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	1,896,968,233.36	1,944,616,032.83
39208	Хуримтлагдсан элэгдэл	(1,412,939,780.23)	(1,621,998,131.26)
393	Биет бус хөрөнгө	1,831,257,520.21	1,848,550,436.73
39301	Програм хангамж	353,093,470.00	361,013,470.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(342,530,969.79)	(348,158,053.27)
39303	Бусад биет бус хөрөнгө	1,820,695,020.00	1,835,695,020.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	42,898,613,372.06	41,357,116,762.24
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	11,792,080.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	11,792,080.00
413	Өглөг	-	11,792,080.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	11,792,080.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	42,898,613,372.06	41,345,324,682.24
51	Засгийн газрын хувь оролцоо	42,898,613,372.06	41,345,324,682.24
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	17,104,644,437.50	17,104,644,437.50
51101	Өмч: - төрийн	17,104,644,437.50	17,104,644,437.50
512	Хуримтлагдсан үр дүн	4,776,452,297.53	3,223,163,607.71
51210	Өмнөх үеийн үр дүн	7,310,673,183.88	4,578,266,713.68
51220	Тайлант үеийн үр дүн	(2,534,220,886.35)	(1,355,103,105.97)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	21,017,516,637.03	21,017,516,637.03
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	42,898,613,372.06	41,357,116,762.24

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

